Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр				
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр				
<b>ТАТААС</b>	57,024,600.00	57,024,600.00	57,024,600.00	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас				
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	57,024,600.00	57,024,600.00	57,024,600.00	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	57,024,600.00	57,024,600.00	57,024,600.00	
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	80,271,300.00	77,331,450.00	77,331,450.00	500,000.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг				
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	80,271,300.00	77,331,450.00	77,331,450.00	500,000.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж				
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,866,100.00	18,031,200.00	18,031,200.00	
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт				
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,605,200.00	16,605,200.00	16,605,200.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,800,000.00	42,695,050.00	42,695,050.00	500,000.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>546,873,200.00</b>	<b>439,857,839.00</b>		-
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	546,873,200.00	439,857,839.00	-	-
Барилга байгууламж				
Тоног төхөөрөмж				
Бусад хөрөнгө	546,873,200.00	439,857,839.00		
Стратегийн нөөц хөрөнгө				
Гадаад эх үүсвэрээр				
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	504,460,000.00	339,127,300.00	339,127,300.00	339,127,300.00
Эргэж төлөгдөх зээл	504,460,000.00	339,127,300.00	339,127,300.00	339,127,300.00

Арвайхээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл				
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл				
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7,395,701,600.00	7,194,817,562.57	10,611,970,422.57	(175,309,480.11)
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	5,562,595,422.57	(5,562,595,422.57)
Улсын төсвөөс санхүүжих			5,562,595,422.57	(5,562,595,422.57)
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих				
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	6,146,312,300.00	6,575,618,357.57	43,375,000.00	5,887,284,942.46
Орон нутгийн төсвөөс	5,633,289,400.00	6,062,595,422.57		5,887,284,942.46
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	513,022,900.00	513,022,935.00	43,375,000.00	
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих				
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих				
Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт				668,240,608.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,249,389,300.00	619,199,205.00	5,006,000,000.00	(499,999,000.00)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	574,530,000.00	467,632,605.00	347,625,180.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	167,704,000.00	151,566,600.00	600,000.00	1,000.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	507,155,300.00		500,000,000.00	(500,000,000.00)
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				
Хандив тусламж /дотоод/				
Хандив тусламж /гадаад/				
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		40,447,168.95		93,092,044.90
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		198,744,059.95		101,589,924.90

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>168,997,850.00</b>	<b>168,997,850.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>92,703,100.00</b>	<b>92,703,100.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>85,310,100.00</b>	<b>85,310,100.00</b>

Арвайхээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,690,000.00	20,690,000.00
210602	Тавилга	15,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	5,690,000.00	5,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,570,100.00	26,570,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,570,100.00	26,570,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,050,000.00	38,050,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,050,000.00	38,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,393,000.00	7,393,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,393,000.00	7,393,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,393,000.00	7,393,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,294,750.00	76,294,750.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	76,294,750.00	76,294,750.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	168,997,850.00	168,997,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168,997,850.00	168,997,850.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,415,100.00	129,415,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,988,000.00	31,988,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,594,750.00	7,594,750.00

### 3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын санхүүгийн алба нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн албанд дарга-1, мэргэжилтэн-1, нягтлан бодогч -26 нийт 28 орон тоотой ажиллаж байна. Тус суманд төсөвт байгууллага-27, орон нутгийн сан-3 үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын Төрийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Арвайхээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,470.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	821.84	3,176.23	- 2,354.40
Авлага	1,342.87	1,270.92	71.95
Урьдчилгаа	5.16	133.14	- 127.98
Бараа материал	1,641.93	872.96	768.97
Үндсэн хөрөнгө	76,013.07	44,900.87	31,112.20
<b>Нийт хөрөнгө</b>	<b>79,824.86</b>	<b>50,354.13</b>	<b>29,470.74</b>
Өр төлбөр	48.39	30.38	18.01
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	79,776.48	50,323.75	29,452.73
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>79,824.86</b>	<b>50,354.13</b>	<b>29,470.74</b>

Тайлант онд Соёмбо цогцолбор, Тэмүүлэл эрдэм, 3-р цэцэрлэг, 8-р цэцэрлэг, Түшигдөлгөөн ӨЭМТ, Уян сэтгэл ӨЭМТ, Нарны дөш ӨЭМТ, Арвайхээр ТҮК ОӨААТҮГ, 11-

цэцэрлэг, 14-р цэцэрлэг, 12-р цэцэрлэгүүдийн авлага буурч эрсдэлээс хамгаалах сан, ЗДТГ, Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, ИТХ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Сум хөгжүүлэх сангийн авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 769.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 31,113.2 сая төгрөгөөр буурсан нь ЕБС, цэцэрлэгүүдийн бараа материал, үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Уян сэтгэл ӨЭМТ, Нарны дөш ӨЭМТ, Арвайхээр ТҮК ОӨААТҮГ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

### Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,176.23 сая төгрөг болж, өмнөх оноос 2,354.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	2.40	0.001	2.40
Банканд байгаа бэлэн мөнгө	819.44	3,176.23	-2,356.80
Төгрөг	2.40	0.001	2.40
Төрийн сангийн харилцах	702.74	3,049.28	-2,346.54
Арилжааны банк дахь харилцах	116.69	126.95	-10.26
<b>Дүн</b>	<b>821.84</b>	<b>3,176.23</b>	<b>-2,354.40</b>

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, Орон нутгийн ерөнхий орлого, эрсдэлээс хамгаалах сан, ОНХС, Сум хөгжүүлэх сан, Түшиг дөлгөөн ӨЭМТ, Уян сэтгэл ӨЭМТ, Нарны дөш ӨЭМТ, Арвайхээр ТҮК ОӨААТҮГ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, ИТХ, ЗДТГ зэрэг байгууллагууд мөнгөн хөрөнгийг үлдэгдэлтэй гарчээ.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,270.92 сая төгрөг болж, өмнөх оноос 71.95 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	8.77	2.29	6.48
Зээлийн хүүгийн авлага	24.46	20.34	4.12
Байгууллагаас авах авлага	303.51	175.06	128.45
Хувь хүмүүсээс авах авлага	1,006.13	1,073.23	-67.10
<b>Дүн</b>	<b>1,342.87</b>	<b>1,270.92</b>	<b>71.95</b>

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт ажилчидтай холбогдсон авлага, зээлийн хүүгийн авлага, байгууллагаас авах авлага буурч, хувь хүмүүсээс авах авлага нэмэгдсэн байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 872.96 сая төгрөг болж, өмнөх оноос 768.97 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	261.99	39.50	222.49
Дуусаагүй үйлдвэрлэл		86.80	-86.80
Бэлэн бүтээгдэхүүн	2.20	1.55	0.65
Хангамжийн материал	1,377.74	745.11	632.63
<b>Дүн</b>	<b>1,641.93</b>	<b>872.96</b>	<b>768.97</b>

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 768.97 сая төгрөгөөр буурсан нь боловсролын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

**3.4.4 Биологийн хөрөнгө**

Биологийн хөрөнгө байхгүй.

**3.4.5 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 44,900.87 сая төгрөг болж, өмнөх оноос 31,112.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>70,757.27</b>	<b>42,175.64</b>	<b>28,581.63</b>
Барилга, байгууламж, орон сууц	53,179.49	27,952.61	25,226.88
Хуримтлагдсан элэгдэл	-5,344.08	-5,370.63	26.55
Авто-тээврийн хэрэгсэл	2,248.55	2,170.69	77.86
Хуримтлагдсан элэгдэл	-1,012.24	-1,124.65	112.40
Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,264.62	1,369.79	1,894.83
Хуримтлагдсан элэгдэл	-1,931.62	-622.69	-1,308.93
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,965.48	345.25	1,620.23
Хуримтлагдсан элэгдэл	-929.96	-176.73	-753.23
Зам, гүүрийн байгууламж	25,726.41	26,562.43	-836.02
Хуримтлагдсан элэгдэл	-13,554.78	-14,727.18	1,172.41
Бусад үндсэн хөрөнгө	12,388.55	11,992.56	395.99
Хуримтлагдсан элэгдэл	-5,603.82	-6,208.13	604.30
Ном	348.34	-	348.34
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,255.80</b>	<b>2,725.23</b>	<b>2,530.57</b>
Програм хангамж	36.95	13.77	23.18
Хуримтлагдсан элэгдэл	-22.54	-6.31	-16.23
Бусад биет бус хөрөнгө	5,241.95	2,774.27	2,467.68
<b>Дүн</b>	<b>76,013.07</b>	<b>44,900.87</b>	<b>31,112.20</b>

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 31,112.2 сая төгрөгөөр буурсан нь боловсролын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой.

Мөн 677,3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 1,943.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэлд тусгажээ.

**3.4.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1.2 сая төгрөг болж, өмнөх оноос 85.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	12.90	2.87	10.03
Байгууллагад төлөх өглөг	33.16	8.73	24.43
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	15.51	-15.51
Хувь хүмүүст төлөх өглөг	2.33	3.26	-0.94
<b>Дүн</b>	<b>86.8</b>	<b>1.2</b>	<b>85.6</b>

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Нарны дөш ӨЭМТ, Арвайхээр ТҮК ОӨААТҮГ, Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, Уян сэтгэл ӨЭМТ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ ертэй гарчээ.

**3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 50,323.75 сая төгрөг болж, өмнөх оноос 29,452.73 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	14,328.79	6,294.63	8,034.16
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>53,452.12</b>	<b>38,375.09</b>	<b>15,077.03</b>
Өмнөх үеийн үр дүн	46,539.56	68,267.75	-21,728.19
Тайлант үеийн үр дүн	6,912.55	- 29,892.66	36,805.21
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,995.58	5,654.03	6,341.55
<b>Дүн</b>	<b>79,776.48</b>	<b>50,323.75</b>	<b>29,452.73</b>

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмчийн дүн буурсан нь улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийн эхний үлдэгдлийг зардалд хааснаас тайлант оны үр дүн буурсантай холбоотой.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Сумын ИТХ-ын 2021 оны 06/06 тоот тогтоолоор 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,703.6 сай төгрөгөөр баталжээ.

2022 оны төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 9/03 тогтоолоор татварын орлогыг 1,142.0 сая төгрөг, аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 1,024.2 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 37.3 сая төгрөгөөр, ЗДТГ-ын урсгал зардлыг 752.9 сая төгрөг, цэцэрлэг, сургуулийн тогтмол зардлыг 889.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Сумын төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 7,073.9 сая төгрөг, татварын бус орлогыг 550.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 8,291.3 сая төгрөг буюу 38 хувиар давж биелжээ.

Хүснэгт-9

төгрөгөөр

Татварын орлого				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого /ХХОАТ 8.1.1-с бусад	150,000,000	299,095,089.69	-149,095,089.69	199.4
ХХОАТ	4,138,285,100	5,947,232,370.30	1,808,947,270.30	143.7
Хөрөнгийн албан татвар буу	5,500,000	6,060,000	-560,000.00	110.2
Улсын тэмдэгтийн хураамж	35,000,000	40,625,192	-5,625,191.95	116.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0	324,000	-324,000.00	0.0
Хог хаягдлын хураамж	260,000,000	326,296,864	-66,296,864.03	125.5
Хөрөнгийн орлого / хадгаламж	500,000,000	589,829,281	-89,829,281.32	118.0
нохойны албан татвар	3,500,000	1,600,000	1,900,000.00	
ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4,000,000	5,879,500	-1,879,500.00	0.0
Газрын төлбөр	260,000,000	258,672,783	1,327,217.00	99.5
ҮХХАТатвар	336,695,800	332,543,021	4,152,779.19	98.8
Хөрөнгө борлуулсны орлого	238,901,100	429,832,853	-190,931,752.67	179.9
Татварын буцаалт	-464,579,000	-617,453,375	152,874,374.52	132.9
<b>Нийт дүн</b>	<b>5,467,303,000</b>	<b>7,620,537,579</b>	<b>-2,153,234,579</b>	<b>139</b>
Татварын бус орлого				
хүү торгуул	550,000,000	670,802,842	-120,802,842	122.0
<b>Нийт дүн</b>	<b>6,017,303,000</b>	<b>8,291,340,422</b>	<b>-2,274,037,422</b>	<b>138</b>

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн ч нохойны албан татвар, газрын төлбөр, ҮХХАТатвар бүрэн биелэгдээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 169.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал засвар, тавилга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын захирал, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Арвайхээр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 14,599.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 145.9.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суманд олгох санхүүгийн дэмжлэг буурч, төсөвтөө хасах тодотгол хийсэн ба тэр хэмжээгээр холбогдох зардлууд хэмнэгдсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Арвайхээр сумын ТТЗ нь 2022 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар ТТЗ-тай холбоотой зөрчил илрээгүй.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 зөрчил<sup>1</sup> илэрч, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

##### 5.2 Албан шаардлага

1. Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Арвайхээр сумын 1-р сургууль нь Төсвийн тухай хуулийн хугацаанд аудитад хамрагдаагүй, хугацаа хоцорсон байна.

Шийдвэрлэлт: Сахилгын шийтгэл ногдуулах хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагуудын ур чадварын нэмэгдлийг улирал тутам ажлын үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулан тухай бүр тогтоож олгох.

**Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 2 байгууллага түүвэрт хамруулсан. / ОНХС, СХСан / Дүгнэлт гарсан 8 байгууллага /ЗДТГ, ИТХ, Уян сэтгэл ӨЭМТ, Арвайхээр ТҮК ОӨААТҮГ, Түшиг дөлгөөн ӨЭМТ, Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, Нарны дөш ӨЭМТ/ Үүнээс хязгаарлалттай санал дүгнэлт-2, өөрчлөлтгүй санал дүгнэлт-6 өгсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт , 107.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 12 албан шаардлага, 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

- **ЗДТГазар**- Арвайхээр сумын Засаг Даргын 2022 оны 12 сарын 21-ны өдрийн А/224 тоот захирамжаар аймгийн Тагнуулын хэлтэст олгохоор заагдсан үйл ажиллагааны дэмжлэг 800.0 мянган төгрөгийг Мөнх арц Богд ХХК-д шилжүүлсэн байна. Аудитын явцад дээрх зардлыг олгох шийдвэр,шилжүүлсэн төлбөрийн хүсэлт нь өөр өөр байна . Тус зардал тухайн байгууллагад дэмжлэг үзүүлэхээр очсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.
  - Өмнөх онд үүссэн авлагыг барагдуулаагүй
  - Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан тушаалтанд 1 удаагийн тэтгэмж олгох шийдвэргүйгээр зөвхөн ажлаас чөлөөлсөн захирамж,мөнгө олгохыг хүссэн өргөдлийг үндэслэн олгосон байна
  - Өв Агро ХХК-д 2022 оны 04 сарын 26-нд 181 тоотоор ӨВ Агро гурил тэжээлийн үйлдвэрт шилжүүлсэн 12000.0 мянган төгрөгийн өвсний үнийг Шилэн дансны мэдээлэлд оруулаагүй байна
- **ИТХ**-Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 8172.9 мянган төгрөгийн хоолны зардлыг шийдвэргүй зарцуулсан, хоолны зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжихгүй байна.
  - Тайлант онд 1025.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалт анхан шатны баримтын бүрдэл дутуу , шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжихгүй байх
  - Кассаар 33715.7 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн боловч тайлан гаргаагүй илтгэх хуудсаар тайлагнасан.
- **ОНХС**-Шилэн дансанд 9 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан
- **СХСан**-зөрчилгүй
- **Уян сэтгэл өрхийн эмнэлэг**-зөрчилгүй
- **Арвайхээр ТҮК ОӨААТҮГ**- Бараа материал авахаар бэлэн мөнгө их хэмжээрээр гасгасан
  - Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан
  - Ажлын хөлснөөс ХХОАТатвар суутгаагүй
- **Түшиг дөлгөөн ӨЭМТ**-зөрчилгүй
- **Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ**-зөрчилгүй
- **Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ**-Урсгал зардлаас Ноёны Элч ХХК-нд 2022 оны 09 сарын 28-нд бараа материалын үнэнд 3000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч материалыг орлого аваагүй үндсэн баримт дутуу байна.
  - Эд хариуцагч 3 удаа солигдсон, бараа материалын сүүлийн хагас жилийн 2569.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний тайлан гаргаагүй, бараа материалын 7 дансаар гүйлгээ хийгдсэн боловч тайланг дансны нэр төрлөөр гаргаагүй бүх бараа материалыг нийлүүлэн эхний хагас жилийн тайлан гаргасан.
- **Нарны дөш ӨЭМТ**-Бараа материалын 15723.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй боловч эд хариуцагчийн тайлан гаргаагүй, бараа материалыг тоолоогүй, эмийн тайлан гаргасан боловч эхний үлдэгдэл зөрүүтэй, шатахууны тайлан гаргаагүй анхан шатны баримтууд дутуу, шаардах хуудсыг данс тус бүрээр салгаж тайлагнаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.
  - Бэлэн мөнгөөр 23502.0 мянган төгрөг зарцуулсан боловч кассын тайлан гаргаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.

-Харилцах данснаас гүйлгээ хийхдээ 22470.9 мянган төгрөгийн гүйлгээг төрийн сангаас хийгдсэн зардлын кодыг өөрчлөн мөнгөн гүйлгээний тайланд тайлагнадаг

- Төрийн сан -Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.
- Арвайхээр сумын 1 дүгээр сургууль Төсвийн тухай хуулийн хугацаанд аудитад хамрагдаагүй, хугацаа хоцорсон зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Арвайхээр ТТЗ	2	0					1	0	1	2		
Дүн	2						1		1	2		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НИЙ ӨДӨР